



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 01 сарын 30 өдөр

Дугаар A/05

Улаанбаатар хот

Гамшгийн эрсдэлийг бууруулах
орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2, 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийг тус тус үндэслэн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус II дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Дүүргийн Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн ажиллах журмын хэрэгжилтийг хангуулж, зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулан ажиллахыг Онцгой байдлын хэлтсийн дарга (Б.Цогбадрах)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (М.Давааням)-д даалгасугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн A/04 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ